



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
E-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ  
СУМЫН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНД**

2020-04-30 № 110  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэлгэрцогт сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэлгэрцогт сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Монгол ардын нам” -ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг,

0012020263


“Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дэлгэрцогт сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дэлгэрцогт сумын сонгуулийн хороонд

Хавсралт .d. . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох  
Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

### **Төрийн үйлчилгээг зөв зохион байгуулж, иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулна**

- Сумын газар зохион байгуулалтыг сайжруулж, иргэн бүрт газар өмчлүүлж дуусгана.
- Сумын хүний нөөцийн бодлого барьж ажиллана.
- Багш, эмч, төрийн албан хаагчдын мэргэжил, мэргэшил, ур чадварыг сайжруулна.
- Сумын эмнэлгийг эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр хангана.
- Сум багийн иргэдэд төрийн үйлчилгээг явуулын байдлаар хүргэдэг тогтолцоог бий болгоно.
- ИТХ-ын төлөөлөгчдийн чадавхийг сайжруулж, иргэдтэйгээ ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ

### **Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бүтээн байгуулалтыг өрнүүлнэ**

- Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, хуучирсан орон сууцнуудыг их засварт оруулна.
- Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Нэгдсэн бохир цэврийн ажлыг дуусгаж, лагерь хорооллыг холбоно
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- Сумын төвийн хогийн цэгийн менежментийг сайжруулж, хашаажуулна
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрыг шинээр барина.
- Сумыг жишиг сум буюу СУМЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР хэрэгжүүлнэ.
- Сумын айл өрхийн эрүүл ахуйг сайжруулах цаашлаад хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор одоо байгаа нүхэн жорлонг шат дараатай эко хөрсний бохирдолгүй соруулдаг жорлонгоор солих ажлыг хэрэгжүүлнэ.



## Уламжлалт мал аж ахуйг фермерийн аж ахуйтай хослуулан хөгжүүлнэ.

- Малын үүлдэр, угсааг сайжруулж, шилмэл сүргийн аж ахуйг хөгжүүлнэ.
- Фермерийн аж ахуйг төрөл бүрээр дэмжиж ажиллана
- Жил бүр алслагдсан бэлчээрт инженерийн хийцтэй гүн өрмийн болон энгийн уурхайн худаг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг зохион байгуулна
- Малын тэжээлийн нөөц, хангамжийг гнэмэгдүүлнэ.
- Малын гаралтай түүхий эд мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлийг дэмжиж ажиллана.
- Малчид бүлгээрээ бүтээгдэхүүнээ зах зээлд зохион байгуулалттайгаар борлуулах тогтвортой системийг бий болгоно.
- Өвөл Зуны хүлэмжийн аж ахуйг дэмжиж ажиллана.
- Мал эмнэлэгийн үйлчилгээг нэмэгдүүлж сайжруулна.
- Цөөн малтай айл өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулна.

## Бизнес эрхлэгчдээ дэмжиж, өрх бүрийн орлогыг нэмэгдүүлнэ

- Сум хөгжлийн сангийн үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлнэ
- Их дээд болон мэргэжлийн сургууль төгсөж байгаа орон нутгийн залуучуудыг нутагтаа ирж ажиллах нөхцөлөөр хангана.
- Хөдөлмөрөө хорших, өрхийн үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- Нийтийн аж ахуй үйлчилгээний чанарыг сайжруулна.

Дэлгэрцогт сумын МАН-ын хороо



*Timje*